

ҮЙЛ



АЖИЛЛАГААНЫ

ТАЙЛАН

2023



Үзэл бодлоо чөлөөтэй
илэрхийлэх эрх чөлөө

ХҮМҮҮНЛЭГ
ИРГЭНИЙ
АРДЧИЛСАН
НИЙГЭМ

ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ
АСУУДЛААРХ ХҮНИЙ ЭРХИЙН
ЗӨРЧЛИЙГ ЗОГСОО



ЗМНЕСТИ
ИНТЕРНАШНЛ

ХҮН БҮРТ ХҮНИЙ ЭРХИЙН
БОЛОВСРОЛ ОЛГОХЫН
ТӨЛӨӨ



ЗМНЕСТИ
ИНТЕРНАШНЛ

ГАРЧИГ



БИД ХЭН БЭ?	3
ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТӨЛӨӨ	7
ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧ, ЭРСДЭЛД БУЙ ХУВЬ ХҮМҮҮСИЙН ТӨЛӨӨ	13
ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН ЭРХИЙН ТӨЛӨӨ	20
ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨ ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД	30
БАЙГУУЛЛАГЫН ӨСӨЛТ, ХӨГЖИЛ	36
2023 ОНД ХЭВЛЭСЭН НОМ, ТОВХИМОЛ	42



ЦАХИМ ХУУДАС
www.amnesty.mn



ФЭЙСБҮҮК
Amnesty International Mongolia/
Монголын Эмнести Интернэшнл



ИНСТАГРАМ
Amnestymongolia



ТВИТТЕР
AmnestyMongolia



ЛИНКД ИН
Amnesty International Mongolia




ЮТҮБ
Amnesty International Mongolia



ЦАХИМ ШУУДАН
Members@amnesty.mn


Өнөөдөр Монгол Улсын хэмжээнд 9000 гаруй гишүүд, дэмжигчидтэй, нийслэл болон орон нутгийн хэмжээнд мэргэжил, болоод сонирхлын 25 бүлэгтэйгээр ажиллаж байна.

хамтрагч
байгууллага






МОНГОЛ УЛСАД



ДЭЛХИЙ ДАХИНД



ҮР НӨЛӨӨ

Эрхийнхээ төлөө бичигцгээе аяны
хүрээнд эрсдэлд буй хүмүүсийн төлөө

19,000+
захидал

илгээлээ.



Хүний эрхийн төлөө

393+


үйл ажиллагаа, нөлөөллийн
уулзалт, сургалтыг хийлээ.



2023 онд давхардсан тоогоор

22,055 идэвхтэн

үйл ажиллагаанд нэгджээ.



2023 онд давхардсан тоогоор

1,029,523 дэмжигч

үйл ажиллагаанд нэгджээ.



УДИРДАХ ЗӨВЛӨЛ



Р. Очирбал
Удирдах зөвлөлийн дарга



Б. Болдсүрэн
Удирдах зөвлөлийн дэд дарга



Б. Мөнхжавхлан
Санхүү хариуцсан гишүүн



Б.Баялагмаа
Хүний эрхийн боловсрол хариуцсан гишүүн



Б.Хүслэн
Кампанит ажил хариуцсан гишүүн



Б.Бадрал
Сан арвижуулалт хариуцсан гишүүн



М.Нандинцэцэг
Гишүүнчлэл хариуцсан гишүүн



Д.Оюунномин
Хэвлэл мэдээлэл хариуцсан гишүүн



Б.Идэржав
Залуучууд хариуцсан гишүүн

ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ



П.Тодрол
Хяналтын зөвлөлийн дарга



С.Нажидмаа
Хяналтын зөвлөлийн гишүүн



М.Чимгээ
Хяналтын зөвлөлийн гишүүн

ГҮЙЦЭТГЭХ ТОВЧОО



Б. Алтантуяа
Гүйцэтгэх захирал



Г. Амарзаяа
Кампанит ажил хариуцсан зохицуулагч



П. Мөнхжаргал
Кампанит ажил хариуцсан зохицуулагч



У. Наранцацрал
Санхүүгийн ажилтан



Я. Цэцэнзаяа
Залуучууд, активизм хариуцсан зохицуулагч



Г. Сүхбат
Өсөлт, хөгжил хариуцсан зохицуулагч



Б. Тэргэл
ХЭБ, сан арвижуулалт хариуцсан зохицуулагч



Б.Азаяа
Касс, ложистик хариуцсан ажилтан



Б.Оюунбат
Цахим, хэвлэл мэдээлэл хариуцсан зохицуулагч



ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТӨЛӨӨХ КАМПАНИТ АЖИЛ ЗОРИЛТ

-Үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг бэхжүүлэх

-Тайван хуран цуглах эрхийг баталгаажуулах



ХҮНИЙ
ЭРХ

35
ЭВ САНАА, ИТГЭЛ НАЙДВАР НЭГ

ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ, ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ ЧӨЛӨӨГ БЭХЖҮҮЛЭХ

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг нухчин дарах, хэвлэлийн эрх чөлөөнд халдаж, дарангуй дэглэм рүү ухрах байдал дэлхий дахины цөөнгүй оронд ажиглагдаж байна. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд суурилсан чөлөөт, хараат бус, олон ургальч хэвлэл мэдээлэл нь хүний бусад бүх эрхийг хамгаалахад амин чухал юм. Эрэн сурвалжлах сэтгүүлчдийн ажлын үр дүнд авлига, албан тушаалын гэмт хэргүүдийг илрүүлж, баримтыг олон нийтэд мэдээлэх нь хүний эрхийн зөрчлийг арилгах, засгийн газарт хариуцлага тооцох анхны алхам болдог.


Тиймээс Монголын Эмнести Интернэшнл 2023 онд Үндсэн хуулиар баталгаажсан үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг бэхжүүлэх чиглэлээр хууль тогтоомж, бодлогод нөлөөлөх, хуульч, сэтгүүлчдийг мэргэшүүлэх, идэвхитэн залуучуудыг чадавхжуулахаар иргэний нийгмийн идэвхитнүүд, залуучууд, сэтгүүлчид, хуульчидтай хамтран ажиллав.

Энэ хүрээнд хүний үндсэн эрх болох үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хамгаалах, эвлэлдэн нэгдэх эрхийг бэхжүүлэх чиглэлээр хуульчдын болон сэтгүүлчдийн сүлжээ бий болгох, нөлөөллийн болон соён гэгээрүүлэх чиглэлээр хамтран ажиллалаа.

Засгийн газар хүний эрх хамгаалагч, сэтгүүлч, идэвхтнүүдийг айлган сүрдүүлэх явдлыг эцэс болгож, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хүндэтгэх, тэр дундаа хэвлэл мэдээллийн хэрэгслийн бие даан ажиллах нөхцөлийг хүлээн зөвшөөрөх шаардлагатайг Эмнести Интернэшнл онцолсон.

Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрийг тохиолдуулан ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний комисс, Хүний эрхийн Үндэсний Комисс, Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл, Глоб Интернэшнл төв, Хэвлэлийн Хүрээлэн, Хэвлэл Мэдээллийн зөвлөлтэй хамтран “Хүний эрхэд суурилсан ирээдүйг бүтээх нь: Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө хүний эрхийг хангах хөшүүрэг мөн” уриан дор эрх чөлөөний форум зохион байгуулж, 150 орчим сэтгүүлч, хуульч, иргэний нийгэм, төрийн байгууллагын төлөөлөл оролцож хэвлэлийн эрх чөлөөнд тулгамдаад байгаа асуудлаар хэлэлцлээ. Мөн өдөр иргэний нийгэм, ТББ-ууд, хэвлэл мэдээллийн байгууллагууд хамтран Сүхбаатарын талбай дээр акц өрнүүлж, үзэл бодлоо илэрхийлэх эрх, хэвлэлийн эрх чөлөөг шаардлаа.





Хүний эрх, эрх чөлөөг түгээн дэлгэрүүлэх, хамгаалах хүрээнд эвлэлдэн нэгдсэн Хүний эрхийн ТББ-ын Форум, Иргэний нийгмийн консерциум, хуульч, хэвлэл мэдээлэл, залуучуудын төрийн бус байгууллагуудтай уулзалт зохион байгуулж, тулгамдаад буй хүний эрхийн олон асуудлаар тухайлбал цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах эрсдэлтэй "Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль"-ийг иргэдийн бодит оролцоо, мэргэжилтнүүдийн санал, дүгнэлтийг үл огоорон Хууль тогтоомжийн тухай хуулийг зөрчин батлах гэж буйд анхаарал хандуулах, батлахгүй байх, хориг тавих зэрэг асуудлаар УИХ, Ерөнхийлөгч, Засгийн газар, олон улсад хандсан уриалга, шаардлага, мэдэгдэл гаргаж, олон нийтийн арга хэмжээ, акцуудыг хамтран зохион байгууллаа.

Монголын Эмнести Интернэшнлээс Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 75 жилийг тохиолдуулан УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороо, НҮБ-ын Монгол дахь суурин төлөөлөгч, ХЭҮК, Хэвлэлийн хүрээлэн, Хэвлэл мэдээллийн байгууллагуудаас зохион байгуулсан хэлэлцүүлэгт тус тус оролцож, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг бэхжүүлэх талаарх санал зөвлөмжөө хүргэж, гарц шийдлүүдийг танилцууллаа.

Кибер тандалтын арга хэрэгслийг ашиглан хүний эрхийн идэвхтэн, сэтгүүлч, улс төрчдийг онилдог, ялангуяа тийм тагнах программыг ил тод худалдаалж, цахим тандалтын зөрчлийг үүсгэж, дэлхий дахинаа хүний эрх, хэвлэл мэдээллийн эрх чөлөө, нийгмийн хөдөлгөөнд ноцтой, хор хөнөөл учруулж байгааг Эмнести Интернэшнл удаа дараа анхааруулсан. Энэ аюул Монгол улсад ч бодитой нүүрлэснийг анхааруулж, холбогдох судалгааны тайланг Монгол хэлнээ хөрвүүлэн олон нийтийн хүртээл болгохын зэрэгцээ холбогдох зарим байгууллагууд тухайлбал УИХ, ХЭҮК болон бусад байгууллагад танилцуулга хийлээ. Мөн "Цахим эрин дэх хүний эрх" хэлэлцүүлэг зохион байгуулснаас гадна байгууллага, хувь хүн, хүний эрх хамгаалагчдын цахим аюулгүй байдлын асуудалд холбогдох байгууллагуудын анхаарлыг хандуулах нөлөөллийн уулзалтуудыг хийх, холбогдох гарын авлага ном товхимол, сургалтын материалуудыг боловсруулан олон нийтэд түгээлээ.



© дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр 2023



© ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХИЙН ТӨЛӨӨ ХУУЛЬЧДЫН СҮЛЖЭЭ БАЙГУУЛАХ ЭСЛӨЛ



ТАЙВАН ХУРАН ЦУГЛАХ ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛАХ

Эмнести Интернэшнл “Жагсагчдыг хамгаал” дэлхий дахины кампанит ажлаараа тайван хуран цуглах эрхийг хууль бусаар хязгаарласан, хориглосон, эрхээ эдэлснийх нь төлөө баривчилж, хорьж, ял шийтгэл оногдуулж байгаа улс орнуудаас олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүрэг, амлалтаа биелүүлэхийг шаардаж байгаа билээ.

Монгол улс нь Үндсэн хуулийнхаа 16 дугаар зүйлийн 16-д үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөг баталгаажуулсан. Гэвч цахим болон цахим бус орчинд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлснийх нь төлөө Эрүүгийн хуулиар шийтгэх, эсхүл тайван замаар жагсаал цуглаан хийх тухай мэдэгдлийг нь бүртгэхээс үндэслэлгүйгээр татгалзах, аяндаа үүссэн жагсаал цуглааныг бүртгэлгүй гэдгээр шалтаглан тараах, эсхүл оролцогчдыг шийтгэхээр айлгах зэргээр практик дээр энэ эрхийг хязгаарласаар байна.

Монголын Эмнести Интернэшнлээс тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөг бүрэн баталгаажуулахын тулд Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийг шинэчлэн сайжруулах, хууль сахиулагчдын зүгээс жагсаал цуглааны үеэр олон улсын хэм хэмжээг баримтлан хэв журам сахиулах талаар www.vip76.mn сайт дээр цахим хэлэлцүүлэг өрнүүлж, хуульч, судлаач, шинжээчдийн санал, бодлыг сонслоо.

Тайван жагсах эрхийг хүндэтгэн хамгаалж, хэрэгжүүлэхэд иргэний нийгэм, хүний эрхийн идэвхтнүүдийн хараа хяналтыг бий болгох зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүний эрхийн асуудлаар ажилладаг төрийн бус байгууллагын төлөөлөл, Монголын Эмнести Интернэшнлийн залуу идэвхтэн гишүүдэд “Жагсаал цуглаан ба хүний эрхийн ажиглагч” сургалтыг зохион байгуулж, аливаа жагсаал цуглааны үеийн хэв журам сахиулах үйл ажиллагаанд хүний эрхийн мониторинг, ажиглалт хийх чадавхийг нь нэмэгдүүлэв.



Монголын Эмнести
Интернэшнлийн гишүүд
дэмжигчид Иран улсад тайван
замаар эрхээ шаардаж,
эсэргүүцлээ илэрхийлсэн олон
зуун жагсагчдыг хууль бусаар
баривчлан, хорьж, цаазаар авах
ялаар шийтгэж байгааг
эсэргүүцсэн, Тайландын жагсагч
хүүхэд залуучуудыг хамгаалахыг
шаардсан олон улсын
активизмд нэгдэж, захидал
илгээлээ. Оюутан, залуучууд,
сурагчдын бүлгийн идэвхтэн
гишүүд Ираны эмэгтэйчүүдийн
эрхийг шаардсан, Тайландын
жагсагч хүүхэд залуучуудад
тайван замаар тэмцсэнийх нь
төлөө ял шийтгэл оногдуулахгүй
байхыг уриалсан рийлс, видео,
фото зургаа оруулж, цахим
идэвхжил өрнүүлж, хэлэлцүүлэг
зохион байгууллаа.

Эрүүдэн шүүх болон бусад хэрцгий, хүнлэг бус харьцаанаас урьдчилан сэргийлэх нь

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад дэлхийн 173 улс, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцид 177 улс гарын үсэг зурж, нэгдэн оржээ. Монгол улс нь тус пакт, конвенц болон нэмэлт протоколуудад нэгдэн орж, 2017 оноос хэрэгжиж эхэлсэн Эрүүгийн хуульдаа эрүү шүүлтийг өргөн хүрээнд тодорхойлсон. Монголын Эмнести Интернэшнлээс ХЭҮК-ын тухай хуульд заасны дагуу 2022 онд байгуулагдсан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай уулзалт хийж, Монгол улсад эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, тус механизмыг чадавхжуулах чиглэлээр санал солилцов.

Монголын Эмнести Интернэшнл эрүүдэн шүүхээс ангид байх эрхийг хамгаалах хүрээнд Монгол улс болон улс орнуудын засгийн газарт хандан эрүү шүүлтийг хориглох, хохирогчдын эрхийг нөхөн сэргээхийг шаардахаас гадна олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхээр хүний эрхийн сэдвээрх цахим хичээлийг Эмнести Академид байршуулж, сошиал орчинд түгээснээр хуульчид, их дээд сургуулийн оюутан залуучууд, иргэд зайнаас үл харгалзан цахим орчинд хүний эрхийн талаарх мэдлэг ойлголтоо нэмэгдүүлэх боломжийг бий болголоо.






КАМПАНИТ АЖЛЫН ГОЛ ҮР ДҮН

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхийг хязгаарласан бодлого, хууль тогтоомж гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллах хуульчдын болоод сэтгүүлчдийн сүлжээ байгуулахад идэвхтэй, үр дүнтэй хамтран ажиллалаа.

Цахим орчин дахь цагдан хяналт, тандалт бодитой нүүрлэж хүний эрхийн идэвхитэн, иргэний нийгмийн байгууллагууд, хуульч, сэтгүүлчид, улс төрчдийг онилж байгааг анхааруулж, цахим аюулгүй байдлын асуудлыг хүний эрхийн хамгаалагчид болоод холбогдох албаны хүмүүсийн анхаарлын төвд орууллаа.

КАМГААЛАГЧИД



Хүний эрх хамгаалагчид сургалтын эхний модуль хичээлд тавтай морилно уу.

Бэлэн болсон үедээ "Эхлэх" товчийг дарна уу





ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧ КАМПАНИТ АЖИЛ

ЗОРИЛТ

- Хүний эрх хамгаалагчийг таниулан хамгаалах, хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийг шаардах
- Эрсдэлд буй хувь хүн, хүний эрх хамгаалагчдыг хамгаалах үйл ажиллагааг бэхжүүлэх,
- Хуулийн хэрэгжилтийг шаардах.
- Хүн бүр хүний эрхийг дээдэлдэг дэлхий ертөнцийг бүтээхэд залуучуудын идэвх оролцоог нэмэгдүүлэх



ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧИЙГ ТАНИУЛАН ХАМГААЛАХ, ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ШААРДАХЫН ТӨЛӨӨ

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал батлагдсаны 75 жил, Хүний эрх хамгаалагчийн тухай тунхаглал батлагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан ХЭҮК, МОНЭС, Монголын Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв, Оюу толгойн хяналт ТББ, Монголын Эмнести Интернэшнл байгууллагууд хамтран Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг сурталчлах, хэрэгжилтийг хангах, хүний эрх, эрх чөлөөг түгээн дэлгэрүүлэх, хүүхэд, охид эмэгтэйчүүд, бэлгийн цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүрээлэн буй орчны асуудал зэрэг өргөн хүрээнд ажиллаж байгаа хүний эрх хамгаалагчдын хувь нэмрийг олон нийтэд таниулан хамгаалах, эрх баригчдаас хүний эрх хамгаалагчийн хамгааллыг сайжруулахад анхаарал хандуулахыг уриалж, олон нийтэд хандсан сургалт, үйл ажиллагаа зохион байгуулж ажиллалаа.

Тухайлбал хүний эрх хамгаалагчдад тулгарч буй сорил, бэрхшээлийн талаар олон нийтэд таниулан хамгаалуулахаар **“Хүний эрх хамгаалагч зоригтон”** хөрөг найрууллын уралдааныг 5 дахь жилдээ зохион байгууллаа. Энэ жилийн хөрөг найрууллын уралдааныг хүний эрхийг хамгаалах салбарт манлайлж, хувь нэмэр оруулж буй хүний эрх хамгаалагчид, хүний эрхийн зүтгэлтнүүдийн үйл ажиллагааг тодорхой жишээн дээр харуулж, **“Мобайл журнализм”** (МОЖО)-ийн арга, техник ашиглан **“Хүн төвтэй түүх”** бүтээх бүтээлийн төрлөөр зарласан.

Энэ арга хэмжээний хүрээнд мөн сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд болон иргэний нийгмийн идэвхитэн нарт МОЖО бүтээл хэрхэн хийх болон хүний эрх хамгаалагчийн талаар мэдлэг ойлголт өгөх сургалт хийснээс гадна сэтгүүлчид, чөлөөт уран бүтээлчдийг хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагаатай танилцах нэг өдрийн аялал зохион байгуулсан. Ингэснээр сэтгүүлчид хүний эрх хамгаалагчтай биечлэн уулзаж, хүрээлэн буй орчин, эрүүл аюулгүй орчинд амьдрах болон эмэгтэйчүүд хүүхдийн эрхийг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр явуулж байгаа үйл ажиллагаа, тулгарч байгаа саад бэрхшээлийн талаар илүү дэлгэрэнгүй ойлголттой болж чадсан юм.

Уралдаанд орон нутгийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн төлөө тэмцэгч, байгаль хамгаалагч, эмэгтэйчүүд, хүүхдийн эрх хамгаалагч, мэдэх эрх, сонгох сонгогдох эрхийн асуудлаарх мэдлэг ойлголтыг түгээгч, цэвэр усаар хангагдах эрх, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, тайван замаар жагсах эрхийг шаардах зэргээр хүний эрхийг хамгаалахын төлөө тууштай тэмцэж байгаа зоригтнуудын тухай нийт 12 видео бүтээл хүлээн авлаа. **“Мэдэх эрх хамгаалагч”, “Шүүхэд ялагдсан ч түүхэнд ялж яваа зоригтон”, “Үр хойчдоо эд хөрөнгөөс илүү амьдрах орчин үлдээе гэсэн зорилгоосоо үл няцагч малчин”, “Иргэний нийгэм үгүй бол ардчилалд агаар дутна”, “Яс нарийн бичиг”** зэрэг бүтээл шагналт байруудыг тус тус эзэллээ.





Хүрээлэн буй орчин, газар нутгаа хамгаалан тэмцэж, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхээ шаардан, эмэгтэйчүүд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, жендэрийн тэгш байдлын төлөө дуу хоолойгоо өргөж байгаа хүний эрх хамгаалагчид тэр дундаа эмэгтэй идэвхтнүүдийг сэтгүүлчид, чөлөөт уран бүтээлчид, хэвлэл мэдээллээр дамжуулан нийгэмд таниулан хамгаалахад тус уралдаан нь чухал үүрэг гүйцэтгэсэн. Мөн Монголын Эмнести Интернэшнл нь хамтрагч байгууллагуудынхаа хамтаар ХЭТТ-ын 75 жил, Хүний эрхийг хамгаалагчийн тухай тунхаглал батлагдсаны 25 жилийн ойн хүрээнд 11 дүгээр сарын 29 буюу “Эмэгтэй хүний эрх хамгаалагчдын өдөр”-өөр хүний эрх хамгаалагчдын өнөөгийн нөхцөл байдал, тэднийг хамгаалах олон улсын болон, үндэсний механизмын хэрэгжилтийн талаар ярилцаж, арга хэмжээнд оролцогчид хүний эрх хамгаалагчдын өдөрт зориулсан Азийн бүсийн хүний эрх хамгаалагчдын эв санааны нэгдлийг харуулсан цахим үйл ажиллагаанд нэгдлээ.

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг бодитоор хэрэгжүүлэхэд Хүний эрх хамгаалагчийн хорооны гишүүд, өмгөөлөгч нар чадавхи онцгой чухал үүрэгтэй. Тиймээс чиглүүлэх сургалт, туршлага солилцох уулзалтуудыг хамтран

зохион байгуулахын зэрэгцээ цахим аюулгүй байдлаа хангах, аюул, эрсдэлийг үнэлэх, даван туулах чиглэлээр МЭИ-ээс сургалт, зөвлөгөө өгч, чиглүүлж оролцлоо. Хүний эрхийн ТББ-ын Форумын дэргэд байгуулагдсан тусгай төсвөөс эрх нь зөрчигдсөн 4 хүний эрх хамгаалагчид өмгөөллийн болон сэтгэлзүйн тусламж дэмжлэг үзүүлж, хүний эрхийн судалгаа хийн, соён гэгээрүүлэх чиглэлээр 5 байгууллага, хуульчдыг дэмжин ажиллалаа.



© ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧИЙН ХОРООНЫ ГИШҮҮДИЙГ ЧАДАВХИЖУУЛАХ СУРГАЛТ



© ЗОРИГТОН УРАЛДААНЫ ШАГНАЛ ГАРДУУЛАХ ЁСЛОЛЫН ҮЕЭР



КАМПАНИТ АЖЛЫН ГОЛ ҮР ДҮН

Хүний эрх, эрх чөлөөг түгээн дэлгэрүүлэх, хамгаалахад оруулж буй хүний эрх хамгаалагчдын хувь нэмрийг олон нийтэд таниулан, 5 дахь жилдээ зохион байгуулж байгаа хөрөг найрууллын уралдааны хүрээнд нийт

75 орчим хүний эрх хамгаалагчдын түүхийг олон нийтэд хүргэлээ.

Дангаараа болон хамтран зохион байгуулсан сургалт, хэлэлцүүлэг, бусад арга хэмжээгээр сэтгүүлч, хуульч, ТББ-ын идэвхитэн болон төрийн алба хаагч нийт

700 гаруй хүнд биечлэн хүрч,

180,000 гаруй хүнд хэвлэл мэдээлэл болон сошиал

сүлжээгээр дамжуулан мэдээллийг түгээв.

“Мобайл журнализм” буюу гар утсаараа видео бүтээл туурвих, хүний эрх хамгаалагчийн цахим аюулгүй байдал, хүний эрх хамгаалагчийн эрсдэлийн үнэлгээ зэрэг сургалтуудаар дамжуулан сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан, хуульч, хүний эрх хамгаалагчдыг чадавхижуулав.

Иргэний болон улс төрийн эрх, эдийн засаг нийгэм соёлын эрхээ шаардан, хариуцлагагүй уул уурхайг эсэргүүцэн, ундны цэвэр ус, ариун цэврийн байгууламжаар хангагдах, сонгох, сонгогдох эрхийн төлөө ажиллаж байгаа эмэгтэй хүний эрх хамгаалагчдыг ойлгох, дэмжих соёлыг бий болгоход хувь нэмрээ оруулсан.

Хүний эрх хамгаалагчийн талаарх цахим хичээлд залуучууд гар бие оролцож, зайнаас үл хамааран хүний эрхийн талаарх мэдлэгээ нэмэгдүүлэх боломжийг олголоо.





ЭРСДЭЛД БУЙ ХУВЬ ХҮН, ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧДЫГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ БЭХЖҮҮЛЭХ, ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ШААРДАХ

“Эрхийнхээ төлөө бичигцгээ” аяны үеэр илгээсэн таны үг, захидал, үйл ажиллагаа шийдвэр гаргагч нарт нөлөөлж, засгийн газрууд эрүүдэн шүүгчидтэй хариуцлага тооцож, үзэл санааны хоригдлуудыг суллаж, илүү олон хүнд эрх чөлөөгөө олж авахад нь тусалдаг. Тухайлбал 2020 оны тавдугаар сард Зимбабвед засгийн газрын эсрэг жагсаал зохион байгуулсных нь дараа 3 эмэгтэйг эрүүдэн шүүж, эрүүгийн хэрэг үүсгэсэн. 2022 оны Эрхийнхээ төлөө бичигцгээ аяны үеэр тэдний төлөө шударга ёсыг шаардсан хагас сая гаруй гарын үсэг, захидал илгээсний үр дүнд 2023 оны долдугаар сарын 4-нд Дээд шүүхээс хэргийг нь цагаатгасан.

Олон улсын хүний эрхийн өдрийг тохиолдуулан Монгол улс төдийгүй 100 гаруй улс орон, газар нутагт Эрхийнхээ төлөө бичигцгээ аян өрнөж, АНУ, Бразил, Өмнөд Африк, Эсватини, Мьянмар, Австрали, Киргизстан, Тунис, АНЭУ, Польш улсад үзэл бодлоо илэрхийлж, газар нутгаа хамгаалж, эмэгтэйчүүдийн эрх, шударга ёыг шаардаж, тайван жагсаал зохион байгуулсныхаа төлөө хоригдож, аюул заналхийлэлд өртөж, эрх нь зөрчигдсөн хувь хүмүүсийн төлөө захидал бичих, гарын үсэг цуглуулах үйл ажиллагааг зохион байгууллаа.

Тус аянд МЭИ-ийн гишүүд, дэмжигчид, орон нутгийн бүлгүүд идэвхтэй оролцож, олон нийтийг хамарсан үйл ажиллагааны үеэр захидал уриалгын аян өрнүүлээ. Энэ аяныг залуучууд манлайлан АШУУИС, МУБИС, Шихихутаг Хууль зүйн сургууль зэрэг их, дээд сургууль, ЕБС-иуд дээр хүний эрхийн акц өрнүүлж, Эрхийнхээ төлөө бичигцгээ аянд нэгдлээ.

Мөн аяны үеэр Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандан НҮБ-ын тунхаглалд заасанчлан иргэдээ хүний эрхийн боловсролоор хангах үүргээ хэрэгжүүлж, хүний эрхийн боловсролыг зөвхөн дунд, дээд боловсролын байгууллагад заах бус цагдаа, хуулийн мэргэжилтнүүд, шүүх захиргааны байгууллагын ажилтнууд зэрэг төрийн бүх албан хаагч, агентлагуудыг хүний эрхийн боловсрол, сургалтаар хангахаа баталгаажуулахыг хүссэн захидалд 1800 гаруй хүн нэгджээ.





Дэлхий даяар хүний эрхийг хүндэтгэх үүрэг болоод хууль дээдлэх ёс тасралтгүй алдагдаж, өнгөрсөн онд улам олон хүнийг үхэлд хүргэж буй мөргөлдөөн илүү нэмэгдэж, уур амьсгалын өөрчлөлтийн хямралын улмаас хүмүүс амь эрсдэж, орон байраа алдаж, амьжиргаанаасаа хагацаж, давхар стандарт буюу ялгамжтай хэм хэмжээ түгээмэл байгааг Эмнести Интернэшнл Дэлхийн хүний эрхийн төлөв байдал 2022/23 тайлангаараа танилцуулсан.

Дэлхийн хүний эрхийн төлөв байдал 2022/23 Монгол дахь тусгал хэлэлцүүлэгт НҮБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, Монгол дахь дипломат төлөөлөгчийн газрын төлөөлөгчид, ХЭҮК, НИТХ, Харилцаа холбооны зохицуулах газар, Хууль сахиулах байгууллагууд, Хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбоо, Хэвлэлийн хүрээлэн зэрэг иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл, хүний эрхийн идэвхитэн, хуульч, судлаач, оюутнууд оролцож үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, тайван хуран цуглах эрх, бусад хүний эрхийн асуудлыг хөндлөө.

Эмнести Интернэшнлийн Дэлхийн хүний эрхийн төлөв байдал 2022/23 тайланд иргэд шударга ёсыг шаардан жагссан, дайны гэмт хэргийг мөрдөн шалгахыг дэмжсэн уриалгууд хүчтэй өрнөснийг дурдахаас гадна Монгол Улсын хүний эрхийн нөхцөл байдлын талаар дараах асуудлыг мөн онцолсон. Үүнд УИХ-д өргөн баригдсан хуулийн төслүүдэд төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд шинэ хязгаарлалт үүсгэх, уул уурхай, бусад хөгжлийн төслийг эсэргүүцсэн жагсагчдыг хорих зүйл заалт агуулагдсан тухай мөн уул уурхайн үйл ажиллагаанаас үүдсэн байгаль орчны доройтлоос малчдыг хамгаалаагүй, хүний эрх хамгаалагчид айлган сүрдүүлэлтэд өртсөн, эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний механизм байгуулагдсан ч, хоригдогсдыг эрүүдэн шүүсэн, тэдэнтэй зүй бус харьцсан гэх гомдлууд гарсаар байгааг дурдсан байна.

НҮБ-ын Ээлжит Дүгнэлт Хэлэлцүүлгийн ирэх оны хуралдаанаар БНХАУ-ын хүний эрхийн нөхцөл байдлыг хэлэлцэхтэй холбогдуулан тус улс дахь хүний эрхийн асуудал тухайлбал үндэсний цөөнх, цаазаар авах ялын хэрэглээ, ялгаварлан гадуурхалт, олон улсын гэрээг соёрхон батлах асуудлаар гаргасан Эмнести Интернэшнлийн зөвлөмжийг анхааран ажиллахыг холбогдох яамны сайдад хандан уриаллаа.





Түүнчлэн НҮБ-ын Шүүгч, хуульчдын хараат бус байдал хариуцсан Тусгай Илтгэгч Маргарет Саттертвейт болон ажлын хэсгийн гишүүд 11 дүгээр сард Монгол улсад айлчлах үеэр Монголын Эмнести Интернэшнлийн ажилтан, хуульчдын бүлгийн төлөөлөл уулзаж, хуульч, шүүгч, цэцийн гишүүдийн хараат бус байдалд нөлөөлж болзошгүй хууль, хуулийн төсөл, өмгөөлөгчдийн ЭХХША-нд оролцох эрхийн практик дахь зөрчил, шударгаар шүүлгэх эрхийн зөрчлийн талаар анхааран судлахыг уриаллаа.

Мөн 11 дүгээр сард НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхлэх Дээд комиссарын газрын Ази, Номхон далайн бүсийн товчооны Дүрвэгсдийн эрх хамгааллын ахлах мэргэжилтэн Жулиа Зажковскитэй Монголын Эмнести Интернэшнлийн ажилтан, чөлөөт бүлгийн төлөөлөл уулзаж, Дүрвэгсдийн конвенцид нэгдэн орох асуудлаарх Эмнести Интернэшнлийн зөвлөмж, монгол дахь орогнол эрэгч, дайнаас дайжигч, дүрвэгчдийн эрх хамгааллын асуудал, нөхцөл байдлын талаар мэдээлэл солилцлоо.

ГОЛ ҮР ДҮН

Монгол улс дахь хүний эрхийн идэвхитэн дэмжигчид өөрийн улс дахь хүний эрхийн үйл ажиллагаанаас гадна дэлхийн бүх бүс нутгийн 15 орны хүний эрх хамгаалагчид болоод, эрсдэлд буй хүмүүсийн төлөө эв санааны нэгдлээ илэрхийлж, үйлдэл хийлээ.

Монгол улсад тулгамдаж буй хүний эрхийн асуудлаас гадна дэлхий дахины хүний эрхийн төлөв байдал бүс нутгийн тоймыг цахимд байршуулан иргэд зайнаас үл хамааран эрхээ мэдэх, гүнзгийрүүлэн судлах боломжийг олголоо.

Дэлхийн хүний эрхийн төлөв байдал, Монгол улсын хүний эрхийн нөхцөл байдлын талаарх мэдээ мэдээллийг 10 орчим телевиз, сайтаар

350,000

гаруй хүнд хүргэлээ.





ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ СОЁЛЫН ЭРХИЙН ТӨЛӨӨ КАМПАНИТ АЖИЛ

ЗОРИЛТ

-Алагчлалгүй, тэгш байдлыг дээдлэх соёл, хандлагыг хүний эрхийн боловсролоор дамжуулан түгээж, жендэрт суурилсан хүчирхийлэл, тэгш бус байдлыг бууруулахад хувь нэмэр оруулах.

-Орон байртай байх, эрүүл байх эрх, нийгмийн халамж, татвар, төсвийн хэмнэлттэй холбоотой бодлогыг хүний эрхэд ээлтэй болгоход иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, эрхийн хэрэгжилтийг сайжруулах.

-Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг олон нийт тэр дундаа нөлөөлөлд буй иргэд болон эрх баригчдын ойлголтыг нэмэгдүүлэх.



АЛАГЧЛАЛГҮЙ, ТЭГШ БАЙДЛЫГ ДЭЭДЛЭХ СОЁЛ, ХАНДЛАГЫГ ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛООР ДАМЖУУЛАН ТҮГЭЭЖ, ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ, ТЭГШ БУС БАЙДЛЫГ БУУРУУЛАХАД ХУВЬ НЭМЭР ОРУУЛАХ

Монголын Эмнести Интернэшнл нь гишүүд, дэмжигчид, иргэд, олон нийтэд үйлдэлд чиглэсэн хүний эрхийн боловсролыг түгээж, хүний эрхийн зөрчлийг арилгах, хамгаалахын төлөө үйлдэл хийх, оролцох мэдлэг, чадвар, хандлагатай болохыг дэмжин ажиллаж байна.

Хүний эрхийг түгээн дэлгэрүүлэх, хамгаалах, бодитойгоор эдлүүлэхэд хүний эрхийн боловсрол чухал үүрэгтэй. Эрхээ мэддэг хүн өөрийн болон бусдын эрхийг хамгаалж, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлж чадна. Иймд НҮБ-ын Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөрийн дагуу улс орнууд хүний эрхийн боловсролыг албан болон албан бус боловсрол, сургалтаар дамжуулан хүүхэд залуус, төрийн бүх албан хаагч, олон нийтэд хүргэх үүрэг хүлээсэн.

Монголын Эмнести Интернэшнл нь Монгол улс хүний эрхийн боловсролын арга зүй, хүртээмжийг нэмэгдүүлж, бүс нутаг болоод үндэсний бодлого, тэргүүлэх зорилтуудад хүний эрхийн боловсролыг эн тэргүүнд тавих, Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөрийг үндэсний хүрээнд цогц хэрэгжүүлэхэд чиглэсэн нөлөөллийн ажлыг бусад хамрагч байгууллагуудын хамт хийсэн. Мөн уламжлал зохион байгуулдаг хөтөлбөр, үйл ажиллагаагаараа дамжуулан хүний эрхийн боловсролыг олон арга замаар түгээлээ.

Хүний эрхэд ээлтэй сургууль хөтөлбөр

Хүний эрхийн үнэт зүйлийг түгээн дэлгэрүүлж, сургуулийн удирдлага, багш эцэг эх, сурагчдын тэгш оролцоог хангах замаар сургуулийн бүхий л орчин дахь хүний эрхийн зөрчлийг арилгаж, хүний эрхийг дээдэлсэн, харилцан бие биенээ хүндэлдэг орчныг бүрдүүлэх зорилготой “Хүний эрхэд ээлтэй сургууль” хөтөлбөрийг энэ онд мөн үргэлжлүүлэн ажиллалаа. ХЭТТ батлагдсаны 75 жилийн огй тохиолдуулан Хүний эрхэд ээлтэй сургууль хөтөлбөрийг сургуулийн удирдлагуудад танилцуулах сургалтыг НБГ-тай хамтран зохион байгуулав. Уг арга хэмжээнд нийслэлийн төрийн болон төрийн бус өмчийн нийт 258 сургуулийн 412 удирдах ажилтнууд хамрагдлаа. Үүнээс 9 дүүргийн 46 сургууль “Хүний эрхэд ээлтэй сургууль болох нь” хөтөлбөрт нэгдлээ. Мөн 2023 онд Дархан, Эрдэнэт хотын 16 сургууль “Хүний эрхэд ээлтэй сургууль болох нь” сургалтад хамрагдаж, сургуулийн орчноо үнэлж, хэрхэн сайжруулах талаар төлөвлөгөө гаргалаа. Уг хөтөлбөрийг 2013 оноос эхлэн өөрийн сургуульд тууштай нэвтрүүлэн, ерөнхий боловсролын сургуульд хүний эрхийн хандлага, соёлыг төлөвшүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж, үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэхэд манлайлал үзүүлсэн нийслэлийн ерөнхий боловсролын 118 дугаар сургуулийг анхны “ХҮНИЙ ЭРХЭД ЭЭЛТЭЙ ЗАГВАР СУРГУУЛЬ” болгон батламжиллаа.





Хүний эрхийг нэгж хичээлийн хөтөлбөрт нэгтгэх нь ур чадварын уралдаан

Хүний эрхийг нэгж хичээлийн хөтөлбөрт нэгтгэх нь ур чадварын уралдааныг 13 дах жилдээ зохион байгуулсан бөгөөд уралдаанд нийт 28 сургуулийн (төрийн өмчийн 23 сургууль, төрийн бус өмчийн 5 сургууль) 41 багш оролцсоны 10 нь хөдөө орон нутгаас, бусад 31 нь Улаанбаатар хотын оролцогч нар байв. Уралдааныг НБГ, Сургуулийн Нийгмийн Ажилтны Нийгэмлэг, ХЭҮК-ийн холбогдох мэргэжилтнүүд хамтран шүүж, албан боловсролын салбар дахь хүний эрхийн боловсрол олгож буй өнөөгийн байдал, чанар, агуулгатай танилцлаа. Хөдөө орон нутгаас Говь-Алтай, Дорнод, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Орхон, Дархан-уул аймгаас багш нар ирж оролцлоо.



Хүний эрхийн боловсрол, сургалтын чиглэлээр хамтын ажиллагаа, нөлөөлөл

Монгол улсын хүний эрхийн боловсролыг олгож, түгээж буй тогтолцоо, арга зүйг хэлэлцэн дүгнэх, хэрхэн сайжруулж, хүртээмжтэй, үр нөлөөтэй болгох асуудлаар хүний эрхийн боловсрол, сургалтын чиглэлээр ажилладаг судлаач, мэргэжилтнүүдийн дунд хэлэлцүүлэг өрнүүлэх зорилгоор “Хүний эрхийн боловсролын аргазүйн симпозиум” 5 дахь удаагаа ХЭҮК, Монголын Хуульчдын Холбоо, МУИС-ийн Хууль зүйн сургууль, Хүний эрхийг хангах Үндэсний хороотой хамтран зохион байгууллаа. Энэ удаагийн симпозиумд хүний эрхийн боловсрол, сургалтын чиглэлээр ажилладаг төр, иргэний нийгэм, хувийн хэвшил, олон улсын байгууллагын 130 гаруй төлөөлөл, эрдэмтэн, судлаач, хүний эрх хамгаалагч оролцож, НҮБ-ын хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хүний эрхийн боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх тухай хэлэлцлээ. Симпозиумаас Монгол улсын Засгийн газар, холбогдох яамд, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшилд хандсан зөвлөмжүүд гарч, холбогдох талуудыг ХЭТТ-ын 75 жилийн ойн хүрээнд хүний эрхийн боловсролын чиглэлээр тодорхой амлалт авахыг уриаллаа.






Эмнести Интернэшнлийн Ерөнхий нарийн бичгийн дарга Агнес Калламардаас Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 75 жил, Хүний эрх хамгаалагчийн тухай тунхаглалын 25 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ нарт нээлттэй захидал илгээж, Монгол Улс бүс нутгийн хэмжээнд хүний эрхийн боловсрол олгогч, бодлого боловсруулагчдад зориулж олон улсын жишигт нийцсэн хүний эрхийн боловсролыг түгээх, суралцах, хамтын ажиллагааны Азийн Хүний Эрхийн Боловсролын төв байгуулах амлалт өгөхийг уриалсан юм.

Энэхүү захидлыг УИХ-ын Хүндэтгэлийн хуралдаан дээр сонсгож, мөн Швейцарын Женев хотноо болсон “Хүний эрх-75” дээд, өндөр түвшний чуулганы үеэр Монгол Улс нь Ази, Номхон далайн бүсийн Хүний эрхийн сургалт, судалгааны төвийг Улаанбаатар хотод байгуулах амлалтыг өглөө. Бүсийн хүний эрхийн сургалт, судалгааны төвийг байгуулснаар Монгол улсад төдийгүй бүс нутгийн хэмжээнд хүний эрхийн боловсролын хүртээмж, чанар нэмэгдэж, эрдэмтэн, судлаачид, иргэний нийгэм, хүний эрхийн үндэсний байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах

чухал ач холбогдолтой бөгөөд цаашлаад хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлж, эрхээ мэддэг, шаарддаг, хамгаалдаг иргэдийг төлөвшүүлэхэд чиглэсэн хүний эрхийн амжилт боллоо.

Урлагаар дамжуулан олон нийтэд хүний эрхийн боловсрол олгох

Монгол улсад болж буй хүний эрхийн зөрчлийн тухай танин мэдүүлэх зорилго бүхий Монголын шог зураачдын шогч бийр холбоотой хамтран зохион байгуулдаг “Хүний эрх, эрх чөлөө” шог зургийн үзэсгэлэнг 5 дахь жилдээ “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө” сэдвийн дор толилууллаа. Үзэсгэлэнд 15 шог зураачийн 75 бүтээлийг дэлгэсэн бөгөөд жагсаал цуглаан хийх мэдэгдэл авахтай холбоотойгоор иргэдийн тайван замаар хуран цуглах эрхээ зөрчигдөж буй тухай, малчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүний эрх хамгаалагчид, сэтгүүлчдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, хэвлэн нийтлэх эрхэд учирч буй асуудлыг шогч байдлаар ёгтлон дүрсэлж, олон нийтийг үйлдэл хийхэд уриалсан.



Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсны 75 жилийн ой, хүний эрх хамгаалагчдын тунхаглалын 25 жилийн ойг угтан зохион байгуулсан энэ удаагийн үзэсгэлэнгийн шилдэг бүтээлээр шог зураач А.Амарсайханы бүтээл шалгарч, эрх баригчид тайван замаар хуран цуглах эрхэд саад учруулж буй асуудлыг олон нийтэд хүргэлээ. Тус үзэсгэлэнгийн шилдэг бүтээлүүдээр нүүдлийн үзэсгэлэнг зохион байгуулж их сургууль болон олон нийтийн арга хэмжээний үеэр аялууллаа. Мөн уур амьсгалын өөрчлөлт ба хүний эрх сэдвийн дор зохион байгуулсан “Хүний эрх эрх чөлөө IV” үзэсгэлэнгийн шилдэг 100 бүтээлийг Дархан хотноо 7 хоног дэлгэж, малчид, залуус, эмэгтэйчүүдийн эрх уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн хэрхэн зөрчигдөж буй талаар 1000 хүнд мэдлэг түгээсэн.


Эрх зүйн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих нь

Монголын Эмнести Интернэшнл нь Эрх зүйн үндэсний хөтөлбөрийн дараах зорилгуудыг дэмжин ажиллала. Үүнд бүх нийтийн эрх зүйн боловсролын агуулга, арга зүйг хүний эрхэд суурилсан хандлага, арга зүйд нийцүүлэн боловсронгуй болгох тухайлан иргэдийн хэрэгцээ шаардлагад тулгуурласан зорилтот бүлгийн нас, сэтгэхүйн онцлог, нийтлэг болон тусгай хэрэгцээ шаардлагад нь тохирсон хүний эрхэд суурилсан хандлага, арга зүйд нийцүүлэн боловсруулах; хууль тогтоомжийг олон нийтэд энгийн, ойлгомжтой хэлбэрээр тайлбарлан таниула; иргэдэд эрх зүйн болон хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг түгээх, тэднийг чадавхжуулах, хүний эрхийн зөрчлийг ялгаж таних, эрх зүйн харилцаанд бие даан оролцох чадварыг эзэмшүүлэх эрх зүйн шаталсан сургалтын тогтолцоог бүрдүүлэх; эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, судалгаанд мэдээллийн технологийг ашиглах;



эрх зүйн мэргэжлээр сургалт явуулдаг их, дээд сургуулиуд болон төрийн бус байгууллагуудын дэргэдэх хууль зүйн клиник төвөөс иргэдэд эрх зүйн болон хүний эрхийн анхан шатны зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, эрх зүйч мэргэжлээр сурч буй оюутнуудын эрх зүйн хөтөөр ажиллах сайн дурын үйл ажиллагааг бүх талаар дэмжих; Иргэдэд эрх зүйн боловсрол олгох үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр МУИС-ын ХЗС, Шихихутуг их сургууль, Отгонтэнгэр их сургуультай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж, эрх нь зөрчигдсөн иргэдийг хамгаалах, хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх үйл ажиллагаанд оюутан залуусын оролцоог нэмэгдүүлэх, хүний эрхийн талаарх олон улсын хэм хэмжээ болон үндэсний хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэглэхэд оюутнуудыг дадлагажуулах, талууд хамтран иргэдэд хүний эрхийн талаар хууль зүйн мэдээлэл өгөх сургалт, сурталчилгаа хийхэд хамтарч ажиллав.

Хүний эрх, эрхзүйн ойлголтыг энгийнээр тайлбарлаж зорилтод бүлгүүдэд хүний эрх хамгаалагч, судлаачдын яриаг хүргэх зорилгоор “ЗОРИГТОН” подкастыг 2020 оноос хойш хөтлөн явуулж байна. 2023 онд “Төсөв ба хүний эрх”, “Газрын тухай багц хууль”, “Хот дахин төлөвлөлт”, “Хүний эрхийн боловсролыг шог зургаар дамжуулах хүргэх” зэрэг сэдвийн дор 8 дугаар бэлтгэн, хүний эрхийн мэдээ мэдээллийг түгээжээ.



ОРОН БАЙРТАЙ БАЙХ, ЭРҮҮЛ БАЙХ ЭРХ, НИЙГМИЙН ХАЛАМЖ, ТАТВАР, ТӨСВИЙН ХЭМНЭЛТЭЙ ХОЛБООТОЙ БОДЛОГЫГ ХҮНИЙ ЭРХЭД ЭЭЛТЭЙ БОЛГОХОД ИРГЭДИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ, ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ САЙЖРУУЛАХ

Улсын төсөв, татвар нь хэрхэн хүний эрх тэр дундаа, эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хангахтай холбогдож буйг ойлгуулах нь өнөө үүед чухлаар тавигдаж буй асуудлын нэг билээ. Шударга бус татвар, өрийн дарамт, төсвийн хэмнэлт, нийгмийн хамгааллын асуудал нь Эмнести Интернэшнлийн анхаарлын төвд орж буй шинэ тулгамдсан сэдэв тул 2022-2028 оны Стратегийн нэгдүгээр үе шатанд Монголын Эмнести Интернэшнл нь бэлтгэл хангах, чадавх бий болгоход чиглэсэн ажлаа үргэлжлүүлэв. МЭИ-ийн гишүүд дэмжигчид татварын асуудлаар бодлогын хэлэлцүүлэг 3 удаа зохион байгууллаа. Мөн төсөв ба хүний эрхийн асуудлаар зурагт хуудас гаргах, Зоригтон хүний эрхийн подкастын ээлжит дугаараар подкаст хийж түгээх зэргээр иргэд олон нийтийн анхаарлыг төсөв хүний эрхийн асуудалд хандуулахад чиглэж ажиллаа. Эмнести Интернэшнлийн төсөв болон төсвийн хэмнэлтийн талаарх тайланг гишүүд дэмжигчид болон олон нийтэд танилцуулсан уг ярилцлагыг 11885 хүн үзэж сонирхжээ.

Төсвийн хэмнэлт ба хүний эрх"-ийн асуудлыг эрүүл мэндийн салбарын жишээн дээр тайлбарлах, ХЭҮК болоод холбогдох талуудын анхаарлыг уг асуудал руу чиглүүлэх нь чухал учир энэ чиглэлээр сургалтын модуль боловсруулах, холбогдох байгууллагуудад илтгэл тавих, танилцуулга хийх, "Төсөв ба Хүний эрх" цуврал танилцуулгыг олон нийтэд түгээх зэргээр нөлөөлөл, соён гэгээрлийн ажилд анхаарал хандуулж ажиллав.

Монгол улс дахь төсвийн хэмнэлтийн бодлого, нийгмийн хамгаалал, оновчгүй тогтолцооны талаар судлах, судалгаанд үндэслэн олон нийтэд сургалт, хэлэлцүүлэг хийн соён гэгээрүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах нь ядуурлыг бууруулж, ялгаварлан гадуурхалтыг багасгахад хувь нэмэр болно гэж үзээд гишүүд энэ чиглэлд мэдээлэл түгээх аянд нэгдлээ.

Хот дахин төлөвлөлт ба хүний орон байртай байх эрх

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хамгаалах "Төр үүргээ мэд, биелүүл" кампанит ажлаараа "Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль" болон түүнийг дагалдан гарсан журмуудад олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцсэн хүний эрхийн хамгаалалт бий болгох, эрхээ хамгаалж чаддаг иргэдийн хүчирхэг бүлгүүд бий болгохыг зорьж ажиллав.





Гэр хороолол, ашиглалтын шаардлага хангаагүй орон сууцыг дахин төлөвлөх явцад иргэдийн нүүлгэн шилжүүлэхэд гарч буй, цаашид үүсч, нэмэгдэж, болзошгүй хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шийдэл хайхад дэмжлэг үзүүлэх, олон нийт болон шийдвэр гаргах түвшинд харилцан хамаарал бүхий талуудын анхаарлын төвд асуудлыг хүргэх зорилгоор сэтгүүлчдийн дунд “Хүний эрх ба Хүндээ ээлтэй хот” бүтээлийн уралдааныг Олон улсын хүний эрхийн өдрийг угтан Тогтвортой хөгжлийн төлөө сэтгүүлчдийн клуб, Дахин төлөвлөлт- Иргэний оролцоо эвсэлтэй хамтран зохион байгууллаа.

Уралдааны тэргүүн байранд “Зууны мэдээ” сонины Эрэн сурвалжилга, шуурхай мэдээний албаны дарга сэтгүүлч С.Уянга “Яндан цөөлөх “хууль”-аар төр эзнээс нь асуухгүйгээр газрыг нь булаах уу? бүтээл, Хоёрдугаар байранд Өнөөдөр.мн сайтын сэтгүүлч Д.Мягмаржаргал “Төрд гологдсон хүүхдүүд”, Цахиур.мн сайтын сэтгүүлч С.Шүрэнчимэг, Д.Нарантуяа “Дахин төлөвлөлт нэрээр иргэдийнхээ орон байртай байх, өмчтэй байх эрхийг зөрчсөөр...” бүтээл, Гуравдугаар байранд ММ агентлагийн сэтгүүлч Н.Баяржаргал “Дахин төлөвлөлт удааширч иргэдийн эрх зөрчигдөж байна”, Пийк.мн сайтын сэтгүүлч Г.Батзаяа “Эрхээ хашаатайгаа хашуулсан 10 жил” бүтээл, Чөлөөт сэтгүүлч А.Уянга “Золиослогдсон эрх” нарын бүтээл тус тус шалгарчээ.



Завхан аймаг, Баянзүрх, Хан-Уул, Сүхбаатар дүүргүүдэд эрх зүйн хөтчийн цэг ажиллалаа. Иргэд, олон нийтэд хүний эрхийн боловсрол олгох, орон байртай байх эрхийн талаар мэдээ, мэдээлэл олгов. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн 3.3.3-т заасны дагуу МУИС-ийн ХЗС-ийн Клиник сургалтын төвтэй хамтран ажиллаж, 45 орчим орон байртай байх эрхийн чиглэлээр эрх зүйн хөтөч оюутан бэлтгэлээ.

2023 онд Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхтэй холбоотой подкаст, постер, комик, мэдээ, мэдээлэл цахим болон цахим бус орчинд давтагдсан тоогоор

600,000

гаруй хүнд хүрсэн байна.





Бизнес ба хүний эрх

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс 2011 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 17/4 тоот тогтоолоор бизнесийн үйл ажиллагааны явцад хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааны хүрээг тодорхойлсон 31 зарчим бүхий “Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд” баримт бичгийг батлан гаргасан. “Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд”-д нийгмийн шударга ёс, хөгжил дэвшилд бизнесийн байгууллага шийдвэрлэх үүрэг рольтой болохыг тэмдэглэж, бизнесийн үйл ажиллагаанаас хүний эрхэд учрах сөрөг нөлөөллийг бууруулах, зөрчигдсөн эрхийг сэргээх үр дүнтэй механизм бий болгох талаар төр, хувийн хэвшлийн хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлсон байдаг.

Монгол Улсын Засгийн газар 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдөр 231 дүгээр тогтоолоор “Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө /2023-2027/-г баталсан Ази Номхон далайн бүсийн дөрөв дэх орон болсон.

Уг төлөвлөгөөний дагуу төрийн яам, агентлагуудаас салбарын төлөвлөгөөг боловсруулж, баталсан эсэх, төлөвлөгөөний хэрэгжилт, үйл ажиллагааны явцад олон нийтийн болоод хэвлэл мэдээлэл, сэтгүүлчдийн анхаарлыг хандуулах зорилгоор Хүний эрхийн Форумаас зохион байгуулсан хэвлэлийн бага хуралд оролцохын зэрэгцээ 16 яам, Түгжрэлийг бууруулах үндэсний хороо, Засгийн газрын Тохируулагч 7 агентлаг, Хэрэгжүүлэгч 26 агентлаг зэрэг нийт 50 орчим төрийн байгууллагад хандаж, хэрэгжилтийг хангуулах нөлөөллийн ажил хийлээ.





Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг олон нийт тэр дундаа нөлөөлөлд буй иргэд болон эрх баригчдын ойлголтыг нэмэгдүүлэх

Шихихутуг их сургуулийн санаачилгыг дэмжиж ХЭҮК, УЕП-ын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнтэй хамтран "Хүрээлэн буй орчин ба хүний эрх: Харьцуулсан судлал" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг, зохионбайгуул лаа. ОУ-ын эрдэм шинжилгээний хуралд Япон улсын Мэйжигийн их сургууль, Унгар улсын Дунауйварош их сургууль, ОХУ-ын Уралын Хууль зүйн их сургууль, Эрхүүгийн Их сургууль, МУИС-ийн ХЗС, ДХИС, ОТИС, Шихихутуг их сургуулийн эрдэмтэн, судлаачид болон практик байгууллагын төлөөлөгчдөөс 30 гаруй илтгэл ирүүлснээс хүрээлэн буй орчны асуудлаар шинжлэх ухааны гарц шийдэл хайсан, онол, арга зүйн үнэ цэнтэй асуудал дэвшүүлсэн 13 илтгэлийг хэлэлцүүлснээс Монголын Эмнести Интернэшнл "Уур амьсгалын шударга ёс сэдвээр илтгэл танилцууллаа.

Их дээд сургуулийн оюутан залуусын хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, тэдэнд хүний эрхийн зарчим, философийн онолыг практикт ашиглах чадварыг олгох зорилгоор 15 дахь жилдээ "Философи, хүний эрх" Философийн улсын олимпиадыг Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх ухаан Технологийн их сургууль, Монгол улсын Боловсролын их сургууль, Анагаах ухааны үндэсний их сургууль, Хөдөө аж ахуйн их сургуультай хамтран зохион байгуулж байна. Энэ жилийн олимпиадыг "Уур амьсгалын өөрчлөлт ба хүний эрх" сэдвийн дор зохион байгуулж, 13 их дээд сургуулийн 80 гаруй оюутан залуус уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн гарч буй шударга бус явдал, цэвэр ус, хоол хүнсээр хангагдах эрх, соёлын эрх, ирээдүй хойчийн эрхийн асуудлаар өөрсдийн шийдлийг хэлэлцэн, оюун ухаанаа сорьлоо. Олимпиадад оролцогчид Монгол улс дахь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой хүний эрхийн асуудлыг олон нийтэд таниулах, өөрсдийн өнцгөөс шийдэл санал болгох зорилгоор 13 видео контент бүтээж, цахим орчинд түгээж, 5000 гаруй хүнд хүргэжээ





Дэлхий нийтийн өмнө тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлт, орчны бохирдол, усны хомсдол, байгалийн баялгийн зохисгүй хэрэглээ, ан амьтан, ой мод, өвс ургамлын төрөл зүйл ховордож буй, эдгээр нь хүний амьдралд хэрхэн нөлөөлж байгааг философи, хүний эрх, соёл, ёс зүйн үүднээс эргэцүүлэх, улмаар ёс суртахуунлаг амьдрахын утга учрыг ухааран, хүн байгалийн харилцааны асуудалд шүүмжлэлтэй хандаж, амьдрахуйн шинэлэг шийдэл эрэлхийлж, байгаль, хүний эрхэд ээлтэй, ухамсартай сонголт хийхэд оюутан залуусыг сургах зорилгоор “ Ёс зүйн үүднээс уур амьсгалын өөрчлөлт, хүний эрхийн тольдох нь” эсээ бичлэгийн уралдааныг оюутан залуусын дунд зохион байгууллаа. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой контент, постер, мэдээллийг нийт 250.000 орчим хүнд цахим болон цахим бусаар хүргэлээ.



Үр дүн

132

Хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагаа

102

их, дээд сургууль, ЕБС-тай хамтран ажиллаж

358,309

давхардсан тоогоор хүнд хүрч ажилласан байна.

500+

Хүний эрхийн боловсрол түгээх уралдаан, тэмцээнд багш, сурагч, оюутан, уран бүтээлч, сэтгүүлч, иргэний нийгмийн идэвхитнүүдийг оролцуулсан.

150+

бүтээл

70+

контент хийж

1,000,000+

давхардсан тоогоор хүнд хүрч ажилласан байна.

Хүрээлэн буй орчны бохирдол, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө нийгмийн бүлгүүдэд харилцан адилгүй тусч, маргинал бүлэг, эмэгтэйчүүд, хүүхдүүд илүү хохирч байгаа тухай олон нийтэд таниулах контентууд цахим орчинд 200 000 хүнд хүрч, хүмүүсийг үйлдэл хийхэд уриалжээ.



ХҮН БҮР ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛДЭГ ДЭЛХИЙ ЕРТӨНЦИЙГ БҮТЭЭХЭД ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ИДЭВХИ ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХИЙН ТӨЛӨӨ

ЗОРИЛТ

-МЭИ-ийн хүний эрхийг хамгаалах үйл хэргийн бүх түвшинд хүүхэд, залуучуудын бодитой, үр дүнтэй, утга учиртай оролцоог нэмэгдүүлэх

-МЭИ-ийн залуу гишүүдийн олон талт байдлыг хангах, нийгмийн олон бүлгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх

-Бүс нутгийн болон олон улсын түвшин дэх хүний эрхийн үйл хэрэгт залуучуудын манлайллыг дэмжих



2023 онд давхардсан тоогоор

17,843

залуу идэвхтэн

694,928

залуу дэмжигч

үйл ажиллагаанд нэгджээ.

Залуучуудын оролцоо, дуу хоолой олон улсын болон бүс нутгийн түвшинд

МЭИ-ийн залуу гишүүд, идэвхитнүүд олон улсын болон бүс нутгийн чуулга уулзалтуудад сонгогдон оролцсоноос гадна Ази Номхон далайн бүс нутгийн хүний эрхийн санаачлага болох “Жагсагчдыг Хамгаал” кампанит ажлын залуучуудын багт ажиллаж байна.

МЭИ-ийн сурагчдын бүлгийн гишүүн Ц.Сарнай Австрали улсад ЭИ-ийн бүс нутгийн чуулга уулзалт болон Бельги улсад зохиогдсон Эмнести Интернэшнлийн дэлхийн чуулганд Монголын Эмнести Интернэшнлийн хүүхэд, залуучуудыг төлөөлөн оролцов. Түүнчлэн сурагчдын бүлгийн гишүүн Б.Буянзаяа НҮБ-ын “Залуу Хүний Эрх Хамгаалагчдын Олон Улсын Хурал”-д МЭИ-ийн залуу гишүүдийг төлөөлөв.

”

Эмнести Интернэшнл 45 орны 13-24 насны хүүхэд, залуучуудын амьдралын туршлага, санаа зовнил, нийгмийн сүлжээнд хандах хандлагыг илүү сайн ойлгохын тулд асуулга явуулсан бөгөөд хор хөнөөлтэй контент, хувийн мэдээллийн аюулгүй байдлын улмаас эрх нь ноцтой зөрчигдөж байгааг олж тогтоосон юм.

Инстаграм, Тик Ток, Ютүб, Снэйпчат, Фэйсбүүк зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл нь дэлхий даяар хүүхэд, залуучуудын амьдралын өдөр тутмын хэрэглээ болсон бөгөөд Эмнести Интернэшнлээс явуулсан судалгаанд хамрагдсан залуучуудын 15 цахим талбар дээр 59% нь өдрийн дундаж өдрийн хоёр цагаас илүүг олон нийтийн сүлжээнд өнгөрүүлж байна. Тиймээс МЭИ-ийн залуу гишүүд болон дэмжигчид хүүхэд, залуучуудын цахим орчин дахь эрх, хувийн нууцтай байх эрх, технологи ба хүний эрхийн чиглэлээр олон улсын хэмжээнд өрнөж буй цахим аян, кампанит ажлуудад оролцлоо. Залуус дэлхий дахины болон улс орнуудын хүний эрхийн талаарх мэдээлэлтэй болж эв санааны нэгдлээ илэрхийлэн оролцоо.





Хүний эрхийн төлөөх залуучуудын оролцоо үндэсний түвшинд

2023 онд Монголын Эмнести Интернэшнлийн хүүхэд, залуучуудын 2024-2027 оны тэргүүлэх чиглэлийг тодорхойлж МЭИ-ийн Хүүхэд, Залуучуудын стратегийг шинэчлэн батлахад оролцсоноос гадна Монголын Залуучуудын хөгжлийн бодлого, эрх хамгаалах чиглэлд ХНХЯ, Монголын Залуучуудын эвсэлтэй хамтран ажиллаж, залуучуудын хөгжлийг тодорхойлох цуврал хэлэлцүүлэгт оролцон өөрийн байр суурийг идэвхитэй илэрхийлэн оролцлоо.

“Хүний эрх хамгаалагч залуучууд” манлайлагчдыг бэлтгэх зуны зуслан сургалт

Хүний эрх хамгаалагч залуучуудыг бэлтгэх зуны зуслан сургалтыг 6 дахь жилдээ зохион байгуулж, иргэний болон улс төрийн эрх, эдийн засаг нийгэм соёлын эрхийн талаар ойлголт өгч, хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх, хамгаалах чиглэлээр олон улсын, үндэсний, орон нутгийн түвшинд манлайлан ажиллах орон нутаг, нийслэлийг хамарсан нийт 120 гаруй идэвхтэн залуучуудыг бэлтгэн, үйл ажиллагаанд хамруулаад байна.

Үүнээс 2023 онд Монголын Эмнести Интернэшнлийн 83 залуу манлайлагч хүний эрхийн төлөөх олон нийтэд чиглэсэн 9 үйл ажиллагааг удирдан зохион байгууллаа. Түүнчлэн Хүний эрхийг дээдэлсэн нийгэм цогцлооход төр, иргэний нийгэм, залуучуудын бүтээлч хамтын оролцоо” сэдэвт Залуучуудын хөгжлийн IX чуулганд МЭИ-ийн залуу гишүүд төлөөлөгчөөр оролцохын зэрэгцээ бусад иргэний нийгмийн залуучуудын байгууллага, хүний эрхийн санаачлага, хөдөлгөөнтэй эв санаагаа нэгтгэж, идэвхитэй хамтран ажиллаж, туршлагаа солилцож байна. Түүнээс гадна хүний эрхийн ойлголт мэдлэг, боловсролыг түгээхэд хувь нэмрээ оруулж “Хүний эрхийн нэр томьёонд тодорхойлолт боловсруулах нь” судалгааны ажлын цуврал хэлэлцүүлэгт МЭИ-ийн залуу гишүүдийн төлөөлөл оролцож санал, зөвлөмж хүргүүлэн ажиллаа.





Онцлох арга хэмжээ

Ярьдаг Футболк-2023

Урлагаар дамжуулан хүний эрхийн боловсрол олгох, зураг, илэрхийлэмжээр дамжуулан үзэл бодол, үг хэлэх эрхээ тайван замаар илэрхийлэх илэрхийлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор “Ярьдаг Футболк-2023” хүний эрхийн өдөрлөг зохион байгууллаа. “Ярьдаг Футболк-2023” өдөрлөгийн шилдгээр ЕБ-ын ӨЗБЛАС-ийн сурагч Н.Энхриймаагийн “Эрвээхэй” коллекц шалгарсан юм.

Эмнестигийн клубүүд

МЭИ-ийн хүүхэд, залуучуудын бүлгийн үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх, анги, бүлэг хамт олныг хүний эрхийн үйл ажиллагаанд татан оролцуулахын тулд ЕБС, Их, дээд сургуулиудад түшиглэн Эмнести Клуб байгуулах ажлыг эхлүүлэн клубийн гишүүдтэй зөвлөлдөн жишиг календарчилсан төлөвлөгөө гаргалаа. Залуучууд зориулсан хүний эрхийн өдөрлөгийг Герман-Монголын хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн оюутан хөгжлийн албатай хамтран зохион байгуулж клубуудээ идэвхижүүллээ.

Залуу хүний эрх хамгаалагч-зуны зуслан сургалт - Хамтдаа Ас

Хүний эрхийн боловсролоор дамжуулан дангаараа болон бусадтай хамтран хүний эрхийн төлөө тэмцдэг, хүний эрхийн соёлыг түгээн дэлгэрүүлэх, Эмнести Интернэшнлийн кампанит ажилд манлайлан идэвхтэй оролцох хүний эрх хамгаалагч залуучуудыг бэлтгэх зорилгоор “Залуу хүний эрх хамгаалагч” зуны зуслан сургалтыг 6 дахь жилдээ дахин зохион байгууллаа. Тус сургалтад 18-24 насны 24 залуу хамрагдаж хүний эрхийн манлайлагчаар бэлтгэгдлээ. МЭИ-ийн Залуу хүний эрх хамгаалагч зуны зуслан сургалтын төгсөгч, манлайлагч залуучуудыг идэвхжүүлэх зорилгоор “Хамтдаа Ас”- зуны зуслан сургалтын төгсөгч нарын уулзалтыг зохион байгуулж Монголын Эмнести Интернэшнлийн Хүүхэд, залуучуудын стратегийн хэлэлцүүлгийг өрнүүлж, манлайлагч гишүүдийн санал, санаачилгыг тусгалаа.





Б.Буянзаяа, МЭИ-ийн сурагчдын бүлгийн ахлагч

ЗАЛУУ ИДЭВХТЭНИЙ ТҮҮХ ”

Хүний эрхийн талаар би анх удаа 5-р ангидаа сонсож байсан. Үе тэнгийнхэндээ хүний эрхийн мэдээлэл өгөөд, үе тэнгийн дээрэлхэлтийг эсэргүүцэх үед би их ганцаарддаг байсан. Яагаад гэвэл надад хамт олон байхгүй, миний үнэт зүйлийг ойлгох ойр хүн байхгүй байсан. Тиймээс би 8-р ангиасаа Эмнестид гишүүнээр элссэн. Анх Эмнестид гишүүн болоход надтай ойр үзэл санаа, ижил үнэт зүйлтэй хүмүүс дунд ороод яг л супер баатруудтай уулзаж байгаа мэт санагдсан. Миний бие Австри улсад зохиогдсон НҮБ-ын “Залуу Хүний Эрх Хамгаалагчдын Олон Улсын Хурал”-д МЭИ-ийн залуу гишүүдийг төлөөлөн оролцсон. Тус хурлаар хүний эрх хамгаалагчид, тэр тусмаа залуу хүний эрх хамгаалагч нарт тулгамдаж буй асуудлын талаарх хэлэлцүүлэг өрнөсөн. Монголын хүний эрх хамгаалагч, тэр дундаа залуу хүний эрх хамгаалагчдад ч тулгарч буй асуудал олон байна. Жишээлбэл боловсролын байгууллагууд хүүхдийн эрх, хүний эрхийн үйл ажиллагаанд оролцохыг хязгаарлаж байсан тохиолдлууд бий. Их сургууль, ЕБС-иуд хүүхэд, оюутнуудаас жагсаал, цуглаанд оролцуулахгүй байх амлалт авч, гарын үсэг цуглуулсан. Хэрэв татгалзвал дүнгээр нь шахалт үзүүлж байсан. Энэ мэт олон жишээний гол шалтгаан нь залуу хүмүүс, хүүхдүүд хүний эрхийн талаар дуугараад өөрчлөлт хийх боломжтой гэдгийг олон нийт мэдэхгүй байгаатай холбоотой юм болов уу гэж бодсон. Залуу хүмүүс, хүүхдүүд хуулийг ашиглан өөрсдийгөө хамгаалах тал дээр бэрхшээл тулгардаг. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг хүүхэд болон залуучууд мөн хүүхдийн эрх хамгаалагчид хэрхэн ашиглан өөрсдийгөө хамгаалах талаар бидэнд хариулт хэрэгтэй байна. Хүүхэд өөрийн эрхээ эдлэхээс гадна бусдын эрхийн төлөө ч дуугарах эрхтэй. Тиймээс бусдын эрхийн төлөө дуугарах эрхтэй гэдгийг бид нийгэмд ойлгуулж, тогтмол сануулж байх хэрэгтэй санагдсан. Төгсгөлд нь хэлэхэд тус хурлын үеэр Палестины төлөөлөгч 17 настай Жанет “...Томчууд биднийг үргэлж ирээдүй гэж хэлдэг. Гэтэл би яг одоо яг энд байна шүү дээ...” гэж хэлсэн нь миний сэтгэл маш тод үлдсэн байна. Тиймээс биднийг сонсооч, хүний эрхийн төлөө дуугарах бидний эрхийг хүлээн зөвшөөрөөч, бусдад таниулаач. Бүх хүн эрхээ эдэлдэг ирээдүйг хамтдаа бий болгоцгооё гэж уриалж байна.



Эрхээ мэдье -2023

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад хүний эрхийн боловсролыг мэтгэлцээнээр дамжуулан олгох зорилгоор “Эрхээ мэдье” анхлан мэтгэлцэгч нарын аварга шалгаруулах мэтгэлцээний тэмцээнийг 13 дахь жилдээ Отгонтэнгэр Их Сургууль, Монголын Карл Попперын Мэтгэлцээний Нийгэмлэгтэй хамтран зохион байгуулж байна. 2023 онд 8 аймаг, 9 дүүргийн 128 багийн 384 сурагч оролцож Орхон аймаг Баян-Өндөр сум 5-р сургуулийн Арвис баг тэргүүн байрт, Сэлэнгэ аймаг Сайхан сум 2-р сургуулийн Emerald баг дэд байр, Орхон аймаг Баян Өндөр сум 5-р сургуулийн Abrakadabra баг, Шинэ Монгол Харумафүжи сургуулийн Meraki баг тус бүр гутгаар байранд шалгарлаа. Хүний эрхийн мэдрэмжтэй мэтгэлцэгчээр Дорноговь аймгийн Замын-Үүд сумын 3 дугаар сургуулийн 106 ангийн сурагч Л.Мишээл шалгарлаа.

ГОЛ ҮР ДҮН

МЭИ-ийн залуу гишүүд үндэсний хэмжээний төдийгүй бус нутаг, олон улсын хүний эрхийн хэлэлцүүлгүүдэд амжилттай оролцож дуу хоолойгоо өргөж чаддаг боллоо.

Хүний эрхийн залуу идэвхитнүүд өөрсдөө манлайлан, санаачилан цахим болон цахим бус орчинд хүний эрхийн төлөөх акц өрнүүлэх чадавхитай болсноос гадна 83 манлайлагч 9 үйл ажиллагааг манлайллаа.

Хүний эрхийн мэдээ, мэдлэгийг хүүхэд залуучуудад ээлтэй аргаар хүргэж, хүний эрхийн үйлсэд татан оруулах, сэдэлжүүлэхэд хувь нэмрээ орууллаа.





БАЙГУУЛЛАГЫН ӨСӨЛТ, ХӨГЖИЛ

ЗОРИЛТ

Өөрсдийн нөөц бололцоо, оролцоог хамгийн дээд түвшинд хүргэх



ГИШҮҮД БОЛОН ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО

Бид 2023 онд илүү олон талт, оролцоотой, шилдэг сайн дурын менежменттэй, стресс бухимдалгүй, илүү олон идэвхтэн, дэмжигчдийг дайчилсан байгууллага боллоо.

МЭИ-ийн стратегиуд шинэчлэгдлээ.

Хүний эрхийн талаар тогтсон бодит ойлголт, бат итгэл үнэмшилтэй, хүний эрхийн үйл ажиллагааны үүрэг хариуцлагаа бүрэн ухамсарласан, идэвхи санаачилгатай гишүүд дэмжигчдээр хүрээгээ байнга тэлдэг, илүү их үр нөлөөнд хүрч чадах, илүү хүчтэй, илүү олон талт хөдөлгөөн болгохын төлөө 2024-2027 оны стратегийн тэргүүлэх чиглэлүүд шинэчлэгдлээ.

Стратегийн шинэчлэлийн хүрээнд нийт гишүүдийн хүрээнд цахим болон цахим бусаар 10 гаруй удаа хэлэлцэж, XXII Ерөнхий чуулганаар Хүний эрхийн боловсролын стратеги, Хүүхэд залуучуудын стратеги, Байгууллагын өсөлтийн стратегиудийг шинэчлэн баталлаа.

Удирдлага, манлайлал, байгууллагын чадавх

Удирдах Зөвлөл /УЗ/ нийт 7 удаа хуралдаж, 33 шийдвэр гаргаснаас 30 шийдвэр буюу 91 %-ийн биелэлттэй байна. 3 шийдвэр нь хэрэгжих шатандаа байна. Хяналтын Зөвлөл /ХЗ/ 2 удаа хуралдаж байгууллагын үйл ажиллагаа дүрмийн дагуу явагдаж байгаа эсэхэд хөндлөнгийн хяналт тавьж ажилласан байна. Шинэ УЗ, ХЗ-д зориулсан сургалтад холбогдох гишүүд, манлайллын сургалтад УЗ, ХЗ, бүлгийн ахлагч, манлайлагч гишүүд хамрагдсан

Ажилтнууд, манлайлагч гишүүд чадавхи бэхжүүлэх сургалтуудад идэвхтэй хамрагдлаа. Тухайлбал; олон улсын болон бүсийн төвөөс зохион байгуулсан Жагсаал, цуглааны ажиглагч бэлтгэх сургагч багшийн сургалт, Уур амьсгалын өөрчлөлт, Эрчим хүчний шударга шилжилт, Төсөв, татвар ба хүний эрх, Хөрөнгө босгох, сан арвижуулах, цахим аюулгүй байдлын сургалт, захирлуудад зориулсан манлайллын сургалт, ХЭБ-ын туршлага солилцох сургалт, уулзалт, People power, график дизайн гэх мэт 20 гаруй төрлийн сургалтад хамрагдаж чадавхиа нэмэгдүүллээ.





“Бидний эрх, Бидний дэлхий, Бидний ирээдүй” XXII Ерөнхий Чуулган

Монголын Эмнести Интернэшнлийн (МЭИ) “Бидний эрх, Бидний дэлхий, Бидний ирээдүй” XXII Ерөнхий чуулган 2023 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Чуулганд улс орны өнцөг булан бүрээс ирсэн орон нутгийн төлөөлөгчид, мэргэжил, сонирхлын бүлгүүд, залуучууд, бүсийн төвийн төлөөлөл зэрэг олон талт төлөөлөл оролцлоо.

МЭИ-ийн УЗ-ийн дарга С.Ганчимэг чуулганыг нээж хэлсэн үгэндээ “Олон Улсын Эмнести Интернэшнлийн (ЭИ)-ийн 62 жил, МЭИ-ийн 29 жилийн ой болж байна. Өнөөдөр ЭИ 150 гаруй орны 10 сая гаруй гишүүн, дэмжигчтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Энэхүү чуулганы уриа “Бидний эрх, Бидний дэлхий, Бидний ирээдүй” гэсэн сэдвээр хэлэлцүүлэх болно. НҮБ-ын ХЭТТ-ын 75 жил, Венийн тунхаглалын 30 жил, ХЭХТ-ийн 25 жилийн ой болж байна. Энэхүү ойн жилүүд тохиож байгаа нь үндэсний хэмжээнд хүний эрхийн үйл ажиллагаа, тогтвортой хөгжлийн зорилтуудын хүрээнд энэ чиглэлээрх төрийн үүрэг амлалтыг одоо дахин сануулах, шаардах, хүний эрхийн соёл, нийтлэг хэм хэмжээг дэлгэрүүлэх, нутагшуулах, нөлөөлж ажиллах завшааныг бидэнд олгож байна” хэмээн танилцуулав.



Эмнести Интернэшнл өнгөрсөн жилд хүний эрхийн боловсролын кампанит ажлаараа 4 сая хүнд хүрч ажилласан. Үүнд Монголын Эмнести Интернэшнл ч хувь нэмрээ оруулсан. Ирэх жилүүдэд хамтдаа илүү их хүнд хүрч ажиллахаа амлаж байна.

ЭИ-ийн Бүс нутгийн Хүний эрхийн боловсрол хариуцсан зохицуулагч Сомьяа Димри, МЭИ-ийн XXII Ерөнхий чуулганы үеэр мэндчилгээ дэвшүүллээ.

Мөн НҮБ-ын Монгол дахь Суурин Зохицуулагч Тапан Мишра илгээлтдээ “Би дэлхийн хүний эрхийн хамгийн нэр хүндтэй, нөлөө бүхий байгууллагуудын нэг болох Эмнести Интернэшнлтэй хамтран ажиллаж байгаадаа бахархаж, талархаж байна. Монгол Улс дахь хүний эрхийн асуудал, ялангуяа хүний эрхийн боловсрол, үзэл бодлоо илэрхийлэх, хуран чуулах эрх чөлөө, хөдөлмөрлөх болон орон байртай байх эрх, хүний эрхийг хамгаалагчид, эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцах зэрэг асуудлаар та бүхэн манлайлж байгааг бид үргэлж үнэлсээр ирсэн. Би та бүхний алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс, ололт амжилт, үйл ажиллагаа, сорилт бэрхшээлийг хэрхэн даван туулж байгааг тань хараад биширч, үнэлж байна. “Бидний эрх, бидний дэлхий, бидний ирээдүй” сэдвээр та бүхэн хэлэлцэх гэж байгааг би энэ цаг үед дэлхий дахин болоод үндэсний нөхцөл байдалд хүний эрхийн мөрийн хөтөлбөрийн амин чухал болоод, онц яаралтайг онцолсон сэдэв хэмээн сайшаан дэмжиж байна” хэмээлээ.



Гишүүн өргөжүүлэлт, чадавхжуулах

Байгууллагын үнэт зүйл, үйл ажиллагааны тухай ойлголтыг өгөх шинэ гишүүний сургалтыг цахим болгож, орон зай, цаг хугацаа харгалзахгүйгээр оролцох боломжийг бий болголоо. Бүлэг, гишүүдийн хүрээнд “Хүний эрх энгийн үгээр” цуврал хэлэлцүүлгийг сар бүр тогтмол, мөн “Тайван жагсах эрх, Үзэл бодлоо илэрхийлэх эрх ба олон нийтийн сүлжээ, Үндсэн хууль ба хүний эрх, Технологи ба хүний эрх” зэрэг сэдэвчилсэн хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Түүнчлэн “Төсөв ба хүний эрх, Дүрвэгчдийн эрх, Газрын багц хууль, зэрэг цаг үеийн хэлэлцүүлэг, “Бидэнд өөр дэлхий байхгүй” сэдэвт бүх гишүүдийн 1-р улирлын уулзалт, “Чи өөрөө гэрэл” сэдэвт бүх гишүүдийн 4-р улирлын уулзалтыг зохион байгуулж, бодлого боловсруулах, олон улсын болон дотоодын активизмд нэгдэх зэрэгт гишүүдийн олон талт оролцоог ханган ажиллалаа. Түүнчлэн Японы Осака хотын Эмнести Интернэшнлийн гишүүдтэй Монголын Эмнести Интернэшнлийн гишүүд танилцах уулзалтыг зохион байгуулж, туршлага солилцлоо.

395

Сайн дурын ажилтан

13,900

цагийг хүний эрхийн төлөө зарцуулжээ.

Илүү олон талт байгууллага болохын төлөө

Монголын Эмнести Интернэшнлээс арьс, үндсээр алагчлахын эсрэг сургалтын модультай болж, Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл, Гүйцэтгэх товчоо, манлайлагчдад сургалт орж олон талт сургагч багштай бэлтгэлээ. Түүнчлэн арьс, үндсээр алагчлахын эсрэг линзээр бүх бодлого дүрэм журмаа эргэн харж, зохих өөрчлөлт оруулав.

Бэлтгэгдсэн сургагч багш нар арьс, үндсээр алагчлахын эсрэг соён гэгээрүүлэх 8 удаагийн сургалт, арга хэмжээг Төв аймгийн ЕБС-ийн сургуулиуд, СБД-ийн иргэд, ХУД-ийн иргэд, ДХИС-ийн сонсогч, оюутнууд зэрэг 700 орчим хүнд хүргэлээ.





ОРОН НУТГИЙН БҮЛГҮҮД

Орон нутгийн бүлгүүд идэвхжиж, бие даан зохион байгуулдаг үйл ажиллагаанууд өргөжин тэлэв. Тухайлбал; Архангай, Баян-Өлгий, Завхан, Дархан-Уул, Орхон, Хэнтий зэрэг 6 аймагт Ярьдаг футболк өдөрлөг, эрхийнхээ төлөө бичигцгээе аян тус бүр зохион байгуулагдаж, 16.000 гаруй хүнд хүний эрхийн боловсрол олгож, 9.000 гаруй захидал илгээлээ. Мөн орон нутгийн бүлгүүд цахим болон цахим бусаар Ерөнхий чуулган, бодлогын хэлэлцүүлэг, цаг үеийн хэлэлцүүлгүүдэд идэвхтэй дуу хоолойгоо илэрхийлдэг болов.



Байгууллагын сайн сайхан байдал (Wellbeing)

МЭИ нь байгууллагынхаа сайн сайхан байдлыг дөрвөн тулгуур асуудал буюу аюулгүй байдал ба амьдралын баталгаа, ажиллах орчин ба сэтгэл ханамж, ажлын зорилго ба утга учир, ажил дээрх сэтгэл зүйн болоод бие махбодийн эрүүл мэнд гэсэн өргөн хүрээтэйгээр авч үздэг. Дээрх 4 тулгуур үндсэн хүрээг хамарсан байгууллагын сайн сайхан байдлын тусгай төлөвлөгөөний дагуу бид хүний эрхийн идэвхтэн, гишүүд, ажилтнууд, УЗ, ХЗ-ийн гишүүд, манлайлагч гишүүдийн сайн сайхан байдлыг хангах чиглэлээр олон ажил зохион байгуулж ажиллав.




БҮХ ЗҮЙЛ ТАНААС ЭХЭЛДЭГ

ТАНЫ ТӨЛСӨН ТАТВАР, ХАНДИВ, ХУДАЛДАН АВАЛТ ДАРААХ ЗҮЙЛСЭД ЗАРЦУУЛАГДДАГ.



ҮҮНИЙ ҮР ДҮНД БИД:



ӨГӨӨМӨР ДЭМЖИГЧИД


Эмнести Интернэшнл судалгаа, кампанит ажлуудаараа бусдад танигдсан хэдий ч өгөөмөр дэмжигчидгүйгээр энэ бүхнийг хийх боломжгүй юм.

Хандивласан хөрөнгө нь манай байгууллагын дараах кампанит ажилд хувь нэмэр орууллаа.


- Хүний эрхийн боловсрол
- «Эрүүдэн шүүхийн эсрэг» кампанит ажил
- «Шаардлагад нийцсэн орон байртай байх эрх» кампанит ажил
- Цаазаар авах ялын эсрэг кампанит ажил

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2023 оны нийт санхүүжилт 315528.17 USD



2023 оны нийт зарцуулалт 328541.11 USD



2023 оны хандивлагчид /мөнгөн, мөнгөн бус/:

- Монголын Эмэгтэйчүүдийн сан
- ЮНЕСКО
- МУБИС
- МУИС
- ШУТИС
- Б.Нямжав
- Р.Очирбал

2023 ОНД ХЭВЛЭСЭН НОМ, ТОВХИМОЛ

